

➤ ЯДУУРАЛ НЭМЭГДСЭН ҮҮ?

➤ УЛС ТӨРЧДИЙН ХУЛГАЙ ХИЙДЭГ  
НЭГДСЭН ФРОНТ: ЭРДЭНЭС МОНГОЛ

➤ ТББ-УУДЫГ ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ҮҮ?

IV НҮҮРТ



Д.Жаргалсайхан  
Эдийн засагч, нийтлэлч

БАНКНЫ ЭЗДЭД  
БАРЬЦААЛАГДСАН **МОНГОЛ**

II НҮҮРТ

WEEKLY

# The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ


ЗОРИГЖУУЛНА

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2019.06.27, №11 (103)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,  
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

[www.defacto.mn](http://www.defacto.mn)





Дамбадаржаагийн ЖАРГАЛСАЙХАН

Долоо хоног бүрийн нийтлэл,  
<http://jargaldefacto.com/category/23>

# БАНКНЫ ЭЗДЭД БАРЬЦААЛАГДСАН МОНГОЛ

**О**УВС Монголд санхүүгийн мөрдлөгө явуулж хувийн хэвшил, иргэдийн хамаг нарийн мэдээллүүдийг гадныханд өгөх гэж байна гэж сүүлийн өдрүүдэд хэвлэл, нийгмийн сүлжээгээр шуугиж эхэллээ. Энэ бол үнэн хэрэгтээ арилжааны хэдхэн банкны цөөхөн эздийн эрх ашгийг хамгаалж дэгсдүүлсэн тархи угаалт юм.

*Учир нь арилжааны банкуудын өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн эх үүсвэрийг шалгаж тодруулахгүй бол Монгол мөнгө угаахыг дэмждэг орнуудын “саарал жагсаалтад” орж, эдийн засгийг сэргээх ОУВС-ийн хөтөлбөр зогсох эрсдэлд бид орчихоод байна.*

Монгол улс “саарал жагсаалтад” энэ оны эцсээр орчихвол гадаадын банкууд монголын арилжааны банкуудын харилцах дансыг царцааж, монголчуудын төлбөрийн карт гадаадад ажиллахгүй болно. Гадаадад зорчихдоо валют бэлнээр авч явахаас өөр сонголтгүй болно. Бэлэн валютын хэрэгцээ огцом өссөнөөр төгрөгийн ханш унаж, доллар долоон мянган төгрөг давах юм.

Дээрээс нь ОУВС-ийн хөтөлбөр зогсвол монголын Засгийн газар 2021 оноос 3 тэрбум долларын өрөө төлж чадахгүй, дампуурлаа (дефолт) зарлахаас өөр гарцгүй болно. Валют ховордож, доллар хорин мянган төгрөг болох юм. Эдийн засаг хөл алдаж, өндөр хавцлаас унах болно.

## “СААРАЛ ЖАГСААЛТАД” БУЦАЖ ОРНО

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын байгууллага ФАТФ (FATF) -ын Ази, Номхон далайн бүсийн байгууллага (APG)-ын гишүүнээр Монгол улс 2004 онд элссэн. ФАТФ нь чиг үүргийнхээ дагуу гишүүн орнууддаа зөвлөмж хүргүүлж, үйл ажиллагааг нь тогтмол хянаж дүгнэдэг, тэгэхдээ холбогдох олон улсын байгууллагуудтай хамтран ажилладаг ажээ.

Монгол улс хүлээсэн үүргийнхээ дагуу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиа 2006 онд баталжээ. Санхүүгийн мэдээллийн албыг Монголбанкны дэргэд байгуулж хил дамжсан мөнгөн гүйлгээг бүртгэж, хянадаг болов.

Гэвч Монгол улс хууль журмаа биелүүлэх, хариуцлага тооцох ажлаа хангалтгүй хийж иржээ. 2011 оноос хойш Монголд мөнгө угаасан байж болзошгүй 4345 хүний хэргийг шалгаснаас 46-г нь мөрдөн байцаажээ. Үүнээс зөвхөн 20 хүний хэргийг нь прокурорт шилжүүлж, хоёр хэргийг нь анхан шатны шүүхээс хүнд ял оногдуулжээ. Гэвч Дээд шүүх нь доод

шатны шүүх хуулийн заалтыг буруу ашигласан гээд мөнгө угаах зүйл ангийг хүчингүй болгож, хоёуланг нь хэрэгсэхгүй болгожээ. Үүний нэг нь МИАТ компанийн гурван удирдах албан тушаалтан онгоц даатгуулахдаа 7.2 сая доллар, нөгөөх нь Иргэний нисэхийн ерөнхий газрын дөрвөн ажилтан тендер будлиантуулж 492 мянган долларыг тус тус завшсан хэргүүд байлаа. Гэмт этгээдүүд хил дамжуулсан маш олон гүйлгээг хэд хэдэн банкаар хийжээ.

2013 онд Монгол улс "саарал жагсаалт"-д орсон боловч зарим шаардлагыг нь шуурхай биелүүлж, тодорхой амлалт авч жилийн дараа тэр жагсаалтаас тусгай нөхцөлтэйгээр гарчээ.

2016 онд ФАТФ Монгол улсыг хуулиа сахиулах талаар эрчимтэй ажиллахыг шаардав. Үүнд, эдийн засгийн ил тод байдлыг хангах, банк бус санхүүгийн зах зээлийн хяналтыг сайжруулах, хууль зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх зэргийг оруулжээ. 2017 оны 4-р сард Засгийн газар Мөнгө угаах, терроризмтой тэмцэх үндэсний зөвлөл байгуулав.

**Үр дүн бага гарсан учир Монгол улс өнөөдөр ФАТФ-ын “эрчимтэй хяналтанд” орчихсон, “саарал жагсаалтад” шилжих эсэх нь энэ оны 10-р сард шийдэгдэхээр болоод байна. 2018 оны байдлаар энэхүү саарал жагсаалтад Серби, Тунис, Ирак, Сири, Йемен, Этиоп, Шри Ланка; хар жагсаалтад Иран, Хойд Солонгос зэрэг улсууд ороод байна.**

## “ИЛ ТОД” БОЛГОСОН ГЭХ ДАЛД ХЭРГҮҮДИЙН УРШИГ

Монгол улсад 2007 онд татварын өршөөлийн тухай хууль гарч “зарим этгээдийг албан татвар, нийгмийн даатгалын өр, төлбөрийн тодорхой хувиас болон захиргааны хариуцлага, эрүүгийн ялаас нэг удаа чөлөөлөхтэй холбогдсон харилцааг” зохицуулсан.

Өршөөлийн дараагийн хууль 2015.08.07-ны өдөр “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль” нэртэй батлагдав. Батлагдсан өдрөөс хойш 7 сарын дотор татвараа сайн дурын үндсэн дээр үнэн зөв мэдүүлж төлвөл эрүүгийн хэрэг үүсгэхгүй, хариуцлага тооцохгүй, мэдээллийг нууцлах амлалтыг төр өгчээ. Энэ хууль 2007 оныхоосоо ялгаатай нь татвар, нийгмийн даатгалын төлбөрөөс гадна хөдлөх, үл хөдлөх хөрөнгийг хамруулсан юм. Энэ “ил тодын” хуулиар 8794 иргэн, 25 мянган аж ахуйн

нэгж, харьяалалгүй 448 иргэний нийт 33,3 их наяд төгрөгийн хөрөнгө ил болжээ. Энэ тоо нь Монгол улсын эдийн засгаас ч том учир гадаад дотоодын судлаачдын анхаарлыг эхнээсээ татаж, иргэдийн дунд ихээхэн хардлага, эгдүүцэл дагуулсан. Хэдхэн сарын өмнө АТГ-ын дарга Х.Энхжаргал ажлаа өгөхдөө тухайн үеийн эрх баригчид гадаад зах зээлээс бондоор мөнгө босгоод үрэн таран хийснээ энэ хуулиар цайруулсан гэж мэдэгджээ.

**Ямар ч гэсэн монголын хуулиар эх үүсвэрийг нь нууцалсан энэ их хөрөнгийн тодорхой хэсэг нь мөнгө угаасан үйлдэл байж болзошгүй гэж олон улсын байгууллагууд үзэж, боломжтой бүх тохиолдлыг мөрдөн шалгах ажээ.**

## АРИЛЖААНЫ ЗАРИМ БАНКУУД ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨ ХААНААС НЭМСЭН ТУХАЙД

Монгол улс гадаад өрөө төлж чадахгүй болж Ч.Сайханбилэгийн Засгийн газар 2015 онд ОУВС-аас тусламж гуйв. Эдийн засгийг сэргээхийн тулд төсвийн алдагдлыг багасгах, арилжааны банкуудынхаа чанаргүй зээлийг бууруулах нөхцлийг ОУВС тавьсан юм. Арилжааны банкуудын активын чанарын үнэлгээг хийлгэж 2018 оны эцэст дүрмийн санг нь нийт 511 тэрбум төгрөгөөр өсгөхийг шаарджээ. Бүх банкууд өөрийн хөрөнгөө нэмсэн гэж Монголбанк мэдээлсэн ч, эх үүсвэрийг нь шалгах нөхцлийг ОУВС эдүгээ тавиад байна.

Арилжааны тодорхой банкууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн эх үүсвэрээ мэдэгдэхгүй, шалгуулахгүй гэж Монголбанкинд албан бичиг ирүүлжээ. Тэдгээр банкуудын чанаргүй зээлийн хэмжээ он гараад огцом өсчээ. Тодорхой банкууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэхэд 2015 оны өршөөлийн хуулиар цайрсан, улс төрийн өндөр албан тушаалтнуудын мөнгө хөрөнгө оролцсон гэсэн хардлага нийгэмд ч, олон улсын байгууллагуудад ч үүсээд байна. Энэ талаар нэг сар хоригдоод дөнгөж суллагдсан ХХБ-ны эзэн Д.Эрдэнэбилэг тодорхой мэдүүлсэн байх учиртай.

Ямар ч л гэсэн ФАТФ-ын “саарал жагсаалтад” орох эсэх мөн ОУВС-ийн хөтөлбөр зогсох эсэх нь хэдхэн банкны цөөхөн эздээс одоо хамаарч эхэллээ. Олон улсын байгууллагын тавьж буй шаардлагын дагуу Засгийн газар, Монголбанк, хуулийн байгууллагууд арилжааны тодорхой банкуудын өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн эх үүсвэрийг яаралтай шалгаж, тодруулахыг иргэд шаардаж байна. Төр засгаас ч бас үрэлгэн зардлаа бууруулж, нийтийн хөрөнгийг завшсан түшмэдээс бондын мөнгийг эргүүлж авахыг шаардаж байна.

**Гарал үүсэл нь нууцлагдсан, өршөөлийн мөнгө л авчихаагүй юм бол тодорхой хэдэн арилжааны банкууд яагаад шалгуулахаас цэрвээд байгаа юм бол оо. Ямар ч их хөрөнгө бэлтэй, ямар ч өндөр төрийн албан тушаал хашсан бай хэдхэн этгээдээс болоод Монгол улс Венесуэлийн замаар орох ёсгүй. Банк хөрөнгө барьцаалах нь жирийн л хэрэг. Харин эх орноо барьцаалах нь гэмт хэрэг юм.**



## ДеФакто ТОЙМ

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:  
2019.06.23-ны дугаар  
Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

## ЯДУУРАЛ НЭМЭГДСЭН ҮҮ?

### Үйл явдлын товч:

Өнгөрсөн Баасан гарагт Дэлхийн банктэй хамтран олон улсын аргачлалын дагуу ядуурлын түвшинг хэмждэг Ядуурлын дүр төрх 2018 тайланг Үндэсний Статистикийн Хорооноос танилцууллаа. Энэ судалгааг 2 жил тутам хийдэг бөгөөд энэ өдөр 2018 оны гол үр дүнгийн талаар эхний байдлаар мэдээлэл хүргэсэн. Харин нарийвчилсан дүн шинжилгээг боловсруулсан нэгдсэн тайланг ирэх намар гаргах юм байна.

### Дүгнэлт тайлбар:

#### ЯДУУРЛЫН ТҮВШИН

2018 онд нэг хүний сарын наад захын хэрэглээ буюу ядуурлын шугам 166.5 мянган төгрөг болсон. Энэ нь 2016 оноос 14 хувиар нэмэгдсэн буюу 20 мянган төгрөгөөр нэмэгдсэн. 2016 онд 146.1 мянган төгрөг байсан. Монгол улсын ядуу иргэдийн ихэнх нь 2018 оны ядуурлын шугамаас доош буюу ойролцоо байна. Эдийн засгийн багахан өөрчлөлтөд тухайн өрх эмзэг байна. Эдийн засгийн огцом цочролд ядуурал руу гулсах эрсдэл өндөр байна.

Ядуурал 2014 онд 21.6 хувь болж буурч байсан бол 2016 онд 29.6 хувь болж өсч байжээ. Энэ нь 2016 онд Монгол улсын хүн ам 3 сая 63 мянга байснаас 907.5 мянган хүн ядуу амьдарч байсан гэсэн үг. Харин 2018 онд 28.4 хувь болж 1.2 хувиар буурсан байна. Энэ нь Монгол улсад 3 сая 186 мянган хүний 904.9 мянган хүн болж ядуу хүний тоо өмнөх жилээс 2.6 мянгаар буурсан гэсэн үг. Энэ нь ойролцоогоор 39 мянган хүн өнгөрсөн 2 жилийн хугацаанд ядуурлаас гарсан гэсэн үг.

*Хотод ядуурал нэмэгдсэн буюу 0.1 нэгж хувиар нэмэгдсэн. Харин хөдөө орон нутагт 4.1 хувиар буурсан байна. Ядуурал улсын түвшинд 2018 онд 28.4 хувь, хотод 27.2 хувь, хөдөө 30.8 хувь болсон байна.*

### ЯДУУРЛЫГ АЙМГААР БҮСЧИЛВЭЛ:

**Баруун бүс:** Баян-Өлгий аймагт ядуурал бусад 4 аймгаас бага буюу 24.3 хувь байна. Харин Говь-Алтай аймагт хамгийн их буюу 45.1 хувь байна.

**Хангайн бүс:** Орхон аймагт бусад 5 аймгаас бага буюу 25.1 хувь байна. Харин Архангай аймагт 38.2 хувь буюу хамгийн өндөр байна.

**Төвийн бүс:** Өмнөговь аймаг бусад 6 аймагтай харьцуулахад хамгийн бага буюу 11.8 хувь байна. Харин Говьсүмбэр аймагт ядуурал хамгийн өндөр буюу 51.9 хувь байна.

**Зүүн бүс:** Сүхбаатар аймагт хамгийн бага буюу 30.2 хувь байгаа бол Дорнод аймагт хамгийн өндөр 42.5 хувь байна.

*Улсын хэмжээнд нийт аймгуудын ядуурлыг авч үзвэл Баян-Өлгий, Орхон, Хөвсгөл, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Төв гэсэн аймгуудад ядуурал улсын дунджаас бага байна.*

Ядуурал нь хувийн хэвшил хэр байгааг л харуулж байгаа. Ажилгүйдэл бодитоор байхгүй болохгүй байна гэсэн үг. МУ-ын цөөхөн хэдэн бизнесүүдэд төрийн оролцоо маш их, авлига нь буурахгүй байна. Төртэй холбоогүй хүмүүсийн бизнес нь явахгүй байна. Нөгөө талаас хувийн хэвшил мөнгө босгож бизнесээ санхүүжүүлэхэд өндөр үнэтэй хэвээр байна. Банкны зээлийн хүү өндөр. Ядуурлын хамгийн гол шалтгаан нь иргэд залхуудаа биш, төр засаг нь эдийн засагт дэндүү их хутгалдаад, түшмэдүүд нь дэндүү их авлигад автсан учраас монголчууд ядуу байгаа.

### САРЫН ДУНДАЖ ХЭРЭГЛЭЭ

Сарын дундаж хэрэглээ 2018 онд 279.912 төгрөг болсон байна. Энэ нь 2016 оноос 18.5 хувиар нэмэгдсэн буюу 43 мянган төгрөгөөр өссөн байна. Үнийн нөлөөллийг нь тооцвол 1 хүнд сард

ногдох бодит хэрэглээ 2018 онд 243 мянган төгрөг байна. Энэ нь 2016 оноос 3 хувийн өөрчлөлттэй гэсэн үг.

*2018 онд иргэдийн дундаж хэрэглээ нэмэгдсэн нь ердөөсөө үнийн өсөлттэй холбоотой байна.*

*2016 онд өрхийн орлогын төрлийг харахад зөвхөн тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэн байсан бол*

*2018 онд цалин, тэтгэвэр, тэтгэмж бусад орлого бүгд нэмэгдсэн байна.*

Үнийг төр зохицуулахгүй бол үнэ хэсэг нэмэгдээд эргээд буурна. Бензиний үнэ ч төр.

### ТЭГШ БУС БАЙДАЛ

Хүн амын тэгш бус байдлыг тодорхойлох Жини коэффициент. Хамгийн чинээлэг бүлгийн хэрэглээг хамгийн ядуу бүлгийн хэрэглээтэй харьцуулвал хамгийн ядуу бүлгийн хэрэглээ 2018 онд 7.9 хувийг хамгийн чинээлэг бүлгийн хэрэглээ 40.9 хувийг улсын хэмжээнд эзэлж байна. Энэ ялгаа нь:

- ♦ 2002 онд 5.5 дахин их
- ♦ 2007 онд 5.9 дахин их
- ♦ 2010 онд 5.3 дахин их
- ♦ 2012 онд 5.4 дахин их
- ♦ 2014 онд 5 дахин их
- ♦ 2016 онд 5.1 дахин их
- ♦ 2018 онд 5.2 дахин их байна. Тэгш бус байдал өөрчлөгдөхгүй хэвээр байна гэж хэлж болно.

## УЛС ТӨРЧДИЙН ХУЛГАЙ ХИЙДЭГ НЭГДСЭН ФРОНТ: ЭРДЭНЭС МОНГОЛ

### Үйл явдлын товч:

Өнгөрөгч Лхагва гарагт Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн олон улсын байгууллагаас “Барьцгүй өсөлт: Эрдэнэс монголын үнэлгээ” хурлыг зохион байгууллаа. Энэ хурлаар 2017 он хүртэл “Эрдэнэс Монгол” ХХК-д хийсэн тус байгууллагын хөндлөнгийн үнэлгээг танилцуулсан бөгөөд компанийн засаглал төдийгүй цаашид анхаарах асуудлуудыг тайланд тусгажээ.

### Дүгнэлт тайлбар:

Эрдэнэс Монгол бол нэлээн улс төржсөн, төрийн нэрээр түмний хөрөнгөөр гараа угааж байгаагийн тод жишээ гэдгийг тайланд харуулсан байна лээ. Эрдэнэс Монгол (толгой компани) анх байгуулагдсан 2006 оноос 2015 хүртэл ямар нэг ашиг тайлагнаагүй. Харин 2016-2018 онд тус компани 51.5 сая төгрөг (24 мянган доллар), 20 тэрбум төгрөг (8.3 сая доллар), 21 тэрбум төгрөг (8 сая доллар) цэвэр ашиг олсноо тус тус тайлагнасан байна. Одоогийн байдлаар ихэнх охин болон хамтарсан компаниуд ашиггүй эсхүл улсад ихээхэн алдагдал үүрүүлж



байна. Охин компаниудын хувьд л гэхэд Эрдэнэс Монгол аль хэдийн 350 гаруй сая долларын өр төлбөртэй болжээ. Төрийн аудитаас өөр хараат бус аудит хийлгэх үүрэггүй, санхүү, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрддөггүй бөгөөд охин компаниудын үр ашиг дэлхийн жишигт хүрээгүй.

Дээд түвшний удирдлагын томилгооны шалгуур тодорхойгүй хэвээр. Эрдэнэс Монголын олон үйл ажиллагаа нууцлалаар далдлагдсан хэвээр байна. Захирлууд нь Засгийн газар солигдох бүрт солигдож байна. Улс төрчдийн хулгай хийдэг нэгдсэн фронт болчихоод байна.

Нээлттэй сонгон шалгаруулалт хийж, “Эрдэнэс Монгол” ХК болох ёстой. Одоогийн удирдлагатай байхад нь хэн ч хувьцааг нь авахгүй тул юуны өмнө удирдлага нь өөрчлөгдөх ёстой. Хувийн компаниасаа эзэн нь өөрөө хулгайлдаггүй юм.

## ТББ-УУДЫГ ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ҮҮ?

### Үйл явдлын товч:

1997 онд батлагдсан Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэх зорилгоор Ашгийн бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан. Улмаар хуулийн төсөлтэй холбоотойгоор иргэний нийгмийн байгууллагууд нэгдэж дуу хоолойгоо хүргэх зорилгоор Ардчиллын боловсрол төв 6-р сараас эхлэн оролцогч талуудыг хамруулсан цуврал уулзалтуудыг зохион байгуулж байна.

### Дүгнэлт тайлбар:

Монгол улс Төрийн бус байгууллагын тухай хуулийг анх 1997 онд баталж байсан. Энэ хуулиар төрийн бус байгууллагыг холбоо, сан гэсэн 2 төрөл байхаар боловсруулж байсан. Удалгүй 2002 онд Иргэний хуулийн шинэчлэл хийснээр төрийн бус байгууллага, ашгийн бус хуулийн этгээдийн төрлийг холбоо, сан, хоршоо гэсэн 3 төрөл байхаар зохицуулсан байна. Улмаар Иргэний хууль, төрийн бус байгууллагын тухай

хуулиудын давхардал хийдэл үүсч төрийн бус байгууллага, ашгийн бус байгууллагын төрөл, хэлбэр, зохицуулалтууд төвөгтэй болжээ. Ийнхүү хуулийн цоорхойгоор аливаа байгууллагууд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг мөртлөө ашгийн бус, төрийн бус байгууллагаар бүртгүүлж үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

1997 оноос хойш ТББ-ын тухай хуульд 6 удаа өөрчлөлт орсон. Энэ өөрчлөлтүүд нь төрийн бус байгууллага, ашгийн бус байгууллагатай холбоотой өөрчлөлт биш татварын хууль эсвэл бусад хуульд дагалдан өөрчлөлт орох тохиолдлууд байсан гэж байгаа.

Шинэ хууль батлагдсанаараа төрийн хяналт илүү орох гэж байгаа. Төрөөс санхүүжилт аваад яаж хараат бус ТББ байх вэ гэдэг асуулт байна. ТББ гэдэг бол иргэний нийгмийн суурь. Иргэний нийгэм нь ардчилсан нийгмийн тулгын гурван чулууны нэг.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв  
Тоймын бүрэн эхийг [jargaldefacto.com](http://jargaldefacto.com) вебсайтаас үзэх  
боломжтой.*

GOOGLE STORE



APP STORE



Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл  
[www.jargaldefacto.com](http://www.jargaldefacto.com) болон [www.defacto.mn](http://www.defacto.mn) вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

### РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:  
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:  
Ганбаатарын Жавзмаа

### ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн  
Адъяагийн Тунгалаг

### ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com  
✉ +976 94109342  
🌐 [www.defacto.mn](http://www.defacto.mn)  
[www.jargaldefacto.com](http://www.jargaldefacto.com)



# EVSEG

Mongolian Premium Cashmere

Эх орны үнэт түүхий эд цэвэр монгол ямааны болох ноолуур, тэмээний ноосыг европын өндөр чанартай туслах материал, технологиор чанарын өндөр түвшинд боловсруулж, мэргэжлийн ажилчид инженерүүд, дизайнеруудын сэтгэл шингэсэн ур ухаанаар бүтээгддэг, үндэсний брэнд компани юм.

Эвсэг | Нирун брэндийн үйлдвэрийн төв дэлгүүр нь 1,720 м.кв бөгөөд сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүний 1,500 гаруй загвар, өнгөний өргөн сонголттойгоор хэрэглэгчиддээ үйлчилж байна. Ноолуурын үйлдвэр нь анхан шатнаас эхлэн эцсийн бэлэн бүтээгдэхүүн хүртэлх бүх дамжлагатай, нийт 900 гаруй ажилчидтай цогц үйлдвэрлэл явуулдаг.



#### ҮЙЛДВЭРИЙН ТӨВ ДЭЛГҮҮР

Зайсан явах замд, Богдын хааны ордон музейн баруун урд  
Tel: 11 343595, 9995 3027



#### ЭВСЭГ | НИРУН ДЭЛГҮҮР

Төв номын сангийн хойно / хуучнаар "Бамбарууш кафе" /  
Tel: 11 330217, 9995 3027



#### УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР САЛБАР

Улсын их дэлгүүр 2-р давхар  
Tel: 11 343595, 9995 3027